

**“ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ТУХАЙ” ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД
ЯАМДААС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЧОО**

Батлан хамгаалахын сайдын 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 1а/3720 тоот албан бичгийн хариу:

Д/д	Яамдын нэр	Ирүүлсэн албан бичиг, хариу, санал	Тайлбар
1	ХЗДХЯ	<p>2023.11.09-ний өдрийн 1/5765 дугаар албан бичиг: Хууль зүй, дотоод хэргийн сайд, Батлан хамгаалахын сайдын хамтарсан 2022 оны А/302, А/315 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн боловсруулсан Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлэв.</p> <p>1.Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.2.4 дэх заалтын “хэв журам” гэсний дараа “хамгаалах” гэж, 5.3.1 дэх заалтын “Цэргийн нийтлэг дүрмүүд” гэсний дараа “Цагдаагийн албаны дүрэм” гэж, 5.3.2 дахь заалтын “цагдаагийн алба хаагчийн” гэсний дараа “сахилга” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтын “багийг” гэсний дараа “бэлтгэх үед” гэж, 13 дугаар зүйлийн 13.2.3 заалтын “Цэргийн нийтлэг дүрмүүд” гэсний дараа “Цагдаагийн албаны дүрэм” гэж тус тус нэмэх.</p>	<p>1.Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.2.4 дэх заалтын “хэв журам” гэсний дараа “хамгаалах” гэж, 5.3.1 дэх заалтын “Цэргийн нийтлэг дүрмүүд” гэсний дараа “Цагдаагийн албаны дүрэм” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтын “цагдаагийн багийг” гэсний дараа “бэлтгэх үед” гэж, 13 дугаар зүйлийн 13.2.3 заалтын “Цэргийн нийтлэг дүрмүүд” гэсний дараа “Цагдаагийн албаны дүрэм” гэж тус тус нэмэх саналыг хүлээн авч, хуулийн төсөлд тусгасан.</p> <p>Хуулийн төслийн 5.3.1-т “Цэргийн нийтлэг дүрмүүд, Цагдаагийн албаны дүрэм” гэж заасан бөгөөд Цэргийн нийтлэг дүрмүүд нь Сахилгын дүрмээс, Цагдаагийн албаны дүрэм нь Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрмээс тус тус бүрддэг тул хуулийн төслийн 5.3.2 дахь заалтын “цагдаагийн алба хаагчийн” гэсний дараа “сахилга” гэж нэмэх саналыг хүлээн аваагүй болно.</p>

		<p>2.Энхийг дэмжих ажиллагаанд оролцсон цэргийн алба хаагчийн ажилласан жилийг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т “тайван цагт энхийг дэмжих ажиллагаанд оролцсон цэргийн алба хаагч ... алба хаасан зургаан сар тутмыг найман сард дүйцүүлэн тооцох” гэж заасны дагуу тооцож байна.</p> <p>Цагдаагийн алба хаагч энхийг дэмжих ажиллагаанд оролцсон тохиолдолд ажилласан жилийг дүйцүүлж тооцох эрх зүйн зохицуулалт байхгүй тул Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсгийн “1 жил 4 сараар” гэсний дараа “энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн гурван сар тутмыг дөрвөн сараар” гэж тус хуульд нэмэлт оруулах.</p> <p>3.Хуулийн төслийн 3.1.4 дэх заалтыг “энхийг дэмжих ажиллагааны сургалт, дадлага гэж” энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүн мэдлэг, чадвар олгох, багийн жигдрэлтийг хангах зорилгоор батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж буй арга хэмжээний цогцыг” гэж өөрчлөн найруулах.</p> <p>4.Хуулийн төслийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийн “амь эрсэдсэн” гэснийг “амь насаа алдсан” гэж өөрчлөх саналтай байна.</p>	<p>2.Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсгийн “1 жил 4 сараар” гэсний дараа “энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн гурван сар тутмыг дөрвөн сараар” гэж тус хуульд нэмэлт оруулах саналыг хүлээн авч, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн дагалдах хуулийн төслөөр Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан дээрх эрх зүйн зохицуулалтыг тусгасан болно.</p> <p>3.ХЗДХЯ болон БХЯ-ны Хамтарсан ажлын хэсгээс хуулийн төслийн 3.1.4-т “энхийг дэмжих ажиллагааны сургалт бэлтгэл” гэж олон улсын холбогдох байгууллага, аливаа улсын санаачилгаар зохион байгуулж байгаа тухайн энхийг дэмжих ажиллагаанд гүйцэтгэх үүргийн онцлог, тавигдах шаардлагыг хангахад чиглэсэн мэдлэг, дадлага, ур чадвар олгох, жигдрэлтийг хангах арга хэмжээний нэгдлийг.” гэж томъёолох нь оновчтой гэж үзсэн тул тухайн зохицуулалтыг хэвээр үлдээх нь зүйтэй гэж үзсэн.</p> <p>4.Хуулийн төслийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийн “амь эрсэдсэн” гэснийг “амь насаа алдсан” гэж өөрчлөх саналыг хүлээн авч, хуулийн төслийн дээрх хэсэгт өөрчлөлт оруулсан болно.</p>
2	ГХЯ	2023.10.24-ний өдрийн 09/5677 дугаар албан бичиг: Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дэмжиж байна.	Хуулийн төслийг дэмжсэн.

3	СЯ	<p>2023.10.17-ны өдрийн 01/7663 дугаар албан бичиг: Таны 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 1а/3720 тоот албан бичгээр ирүүлсэн “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн төсөл болон холбогдох бусад баримт бичигтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:</p> <p>1.Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.3.6 дахь заалтад зааснаар “цагийн байдлын өөрчлөлт, үүрэг гүйцэтгэлтийн онцлогт нийцсэн мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн эрхийн хязгаарлалтыг дагаж мөрдөх” үүргийг энхийг дэмжих ажиллагаанд оролцогч цэрэг, цагдаагийн алба хаагч, цэрэг, цагдаагийн бие бүрэлдэхүүн хүлээхээр тусгажээ. Тус заалтад мэдээллийн аюулгүй байдлыг хангахын тулд эрхийн хязгаарлалт хийж, түүнийг дагаж мөрдүүлэх талаар хэт ерөнхий агуулгыг тусгасан байгааг анхаарч, ямар эрхийг хэрхэн, яаж хязгаарлах талаар нарийвчилсан зохицуулалтыг тусгах;</p> <p>2.Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.11 дэх заалтад энхийг дэмжих ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах журмыг Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заасан байна.</p> <p>Гэвч хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Энхийг дэмжих ажиллагаанд оролцогч нь цэргийн алба хаагч, цэрэг, цагдаагийн баг байна.” гэж, 4.3 дахь хэсэгт “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох цэргийн алба хаагчийг Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, цагдаагийн алба хаагчийн Хууль зүй, дотоод</p>	<p>1.Саналын 1 дэх хэсгийг хүлээн авах боломжгүй байна. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй цэргийн багийн бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх аюулгүй байдлыг хангах үүднээс хувийн зорилгоор гар утас, зөөврийн болон суурин компьютер хэрэглэх, интернэт сүлжээ ашиглах эрхийг зарим тохиолдолд хязгаарлах хэрэгцээ, шаардлага үүсдэг болно. Иймд хуулийн төсөлд мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн эрхийн хязгаарлалтыг нарийвчлан тусгах боломжгүй байна.</p> <p>2.Саналын 2 дэх хэсгийг хуулийн төсөлд тодорхой заасан тул хүлээн авах боломжгүй байна. Тухайлбал, Хуулийн төслийн 9.1-д “Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гэсний 9.1.11-т “энхийг дэмжих ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах журмыг батлах.” гэж, 10.1-д “Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гэсний 10.1.7-д “энхийг дэмжих ажиллагаанд оролцсон алба хаагчийн сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах журмыг батлах.” гэж тус тус батлахаар заасан.</p> <p>Хуулийн төслийн 5.1-т Зэвсэгт хүчний цэргийн багийн</p>
---	----	---	--

	<p>хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр тус тус томилон оролцуулна.” гэж тус тус заасан байна. Дээрх хуулийн төслийн зохицуулалтаар энхийг дэмжих ажиллагаанд оролцох цэргийн алба хаагч, цэрэг, цагдаагийн баг, бүрэлдэхүүнийг харьяалсан Засгийн газрын гишүүн томилж байгаа тул энхийг дэмжих ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдрын асуудалд томилгоо хийж буй Засгийн газрын гишүүн бодлогын түвшинд оролцох нь зүйтэй байна.</p> <p>Иймд энхийг дэмжих ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах журмыг хууль зүй, дотоод хэргийн болон батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлахаар хуулийн төсөлд тусгах;</p> <p>3.Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт “Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх үед алба хаагч, хөдөлмөрийн чадвараа алдсан, нас барсан тохиолдолд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас холбогдох комиссын дүгнэлтийг харгалзан нөхөн олговор олгуулах эсэх асуудлыг судлан шийдвэрлүүлэхэд тухайн эрх бүхий албан тушаалтан, байгууллагаас дэмжлэг үзүүлнэ.” гэж заасан боловч эрх бүхий албан тушаалтан, байгууллагаас ямар дэмжлэгийг хэрхэн, яаж үзүүлэх нь тодорхой бус байгааг анхаарах;</p> <p>4.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу Засгийн газрын нөөц сангаас тухайн жилийн төсөвт урьдчилан тооцож,</p>	<p>гүйцэтгэх үүргийг, 5.2-т цагдаагийн багийн гүйцэтгэх үүргийг тус тус заасны дагуу цэрэг, цагдаагийн багийн энхийг дэмжих ажиллагаанд оролцож гүйцэтгэх үүрэг өөр өөр байх тул алба хаагчийн сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах үйл ажиллагааг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар баталсан журмаар зохицуулах нь зүйтэй юм.</p> <p>Мөн дээрх үйл ажиллагааг харьяа байгууллагын материаллаг баазын түшиглэн зохион байгуулдаг.</p> <p>Иймд дээрх журмыг хууль зүй, дотоод хэргийн болон батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлах нь чиг үүргийн хувьд өөр өөр байгууллагын асуудлыг нэг журмаар зохицуулах нь зохимжгүй гэж үзсэн болно.</p> <p>3.Хуулийн төслийн 14.5-т заасан эрх зүйн зохицуулалтад заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас комисс томилогдон ажиллаж, гарсан дүгнэлтийг харгалзан нөхөн олговор олгох эсэх, ямар төрлийн дэмжлэг үзүүлэх эсэх, шаардагдах нөхөн олговрыг НҮБ-аас гаргадаг.</p> <p>Иймд хуулийн төсөлд цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага болон цагдаагийн төв байгууллагаас дээрх нөхцөлд ямар төрлийн дэмжлэгийг хэрхэн, яаж үзүүлэх талаар тодорхой тусгах боломжгүй бөгөөд хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд холбогдох дэмжлэгийг үзүүлэхээр тусгасан болно.</p> <p>4.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдан боловсруулсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах</p>
--	---	--

	<p>төлөвлөн тусгах боломжгүй, хойшлуулшгүй цаг үеийн шинжтэй арга хэмжээ болон гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах, гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлын хүрэлцэхгүй хэсгийг санхүүжүүлэх зориулалттай байх тул Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт шинээр нэмэх “энхийг дэмжих ажиллагаанд оролцох чадавхыг бүрдүүлэх” гэсэн заалтыг хасах;</p> <p>5.Дагалдах хуулийн төсөл болох Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд Засгийн газрын тусгай сангийн төрөлд Цагдаагийн хөгжлийн санг шинээр байгуулахаар тусгажээ. Гэвч Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт “Энэ хуулийн 5.5-д заасан шаардлагыг хангаж байгаа, эсхүл мөн хуулийн 5.6-д заасан үндэслэл бий болсон эсэхийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянан үзэж, дүгнэлт гаргана.” гэж заасан шаардлагыг хангаагүй байгааг анхаарах зэрэг болно.</p>	<p>тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлд тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасан засгийн газрын нөөц сангийн зориулалтад “энхийг дэмжих ажиллагаанд оролцох чадавхыг бүрдүүлэх” харилцааг хамааруулахаар тусгасан болно.</p> <p>Дээрх эрх зүйн зохицуулалтыг тусгаснаар олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахад Монгол Улсын оролцоог нэмэгдүүлэх хүрээнд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн цэрэг, цагдаагийн багийг шинэ төрлийн энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах Засгийн газрын шийдвэр гарсан тохиолдолд үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүний бэлтгэлийг түргэн, шуурхай зохион байгуулахад чухал ач холбогдолтой юм.</p> <p>НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс Монгол Улсын цэрэг, цагдаагийн багийг оролцуулах шийдвэр гарсан нь хуульд заасан урьдчилан төлөвлөн тусгах боломжгүй, хойшлуулшгүй цаг үеийн шинжтэй арга хэмжээнд хамаарах тул Засгийн газрын хуралдаанаар хуулийн төсөл хэлэлцэхэд шийдвэрлэх боломжтой гэж үзэж саналыг хүлээн аваагүй болно.</p> <p>5.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд орж байгаа зарчмын гол өөрчлөлт нь Монгол Улсын цагдаагийн баг энхийг дэмжих ажиллагаанд оролцох эрх зүйн үндсийг тогтоож байгаа асуудал юм.</p> <p>Иймд хуулийн төслийг дагалдан боловсруулсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “Цагдаагийн хөгжлийн сан”-тай холбогдох эрх зүйн зохицуулалтыг тусгасантай холбогдуулан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.7-д заасны дагуу “Цагдаагийн хөгжлийн сан”-г шинээр байгуулах талаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь түүний хэрэгцээ, шаардлагыг зөв үнэлж дүгнэх шаардлагатай.</p>
--	--	---

4	ЭЗХЯ	<p>2023.11.09-ний өдрийн 01/2094 дүгээр албан бичиг: Танаас 2023 оны 1а/3720 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох материалтай танилцаж дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:</p> <p>1.Тус хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, 8.1.6-д тус тус заасан олон нийт, холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлэх ажил, мэргэжлийн ба судалгааны байгууллагын саналыг авч, холбогдох дүгнэлтийг хийх;</p> <p>2.Хуулийн төсөлд тусгагдсан “болон” гэснийг Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын 4.2.4.2-т “болон”, “эсхүл”, “буюу” гэсэн холбоос үг нь нэг бол, үгүй бол, аль нэг нь гэсэн утгаар өгүүлбэрийн гишүүдийг зэрэгцүүлэн холбоно.” гэж заасны дагуу ашиглах нь зүйтэй тул төслийн зүйл, заалтын агуулгаас хамаарч зарим тохиолдолд “эсхүл” гэсэн үгээр солих;</p> <p>3.Төслийн 3.1.4-т “энхийг дэмжих ажиллагааны сургалт бэлтгэл” гэснийг “сургалт бэлтгэл” гэж өөрчлөх;</p>	<p>1.Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.5-д “эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах;” гэж заасны дагуу Зэвсэгт хүчний Жанжин штабаас харьяа командлал, нэгтгэл, анги байгууллагуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулан саналыг нэгтгэж, Батлан хамгаалах яаманд ирүүлсэн. Мөн хуулийн 8.1.6-д заасны дагуу хуулийн төсөлд ҮБХИС-ийн Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, БХЯ, ЗХЖШ-ын Ахмадын хорооноос санал авсан.</p> <p>2.Саналыг хүлээн авч, “Хуулийн төсөл боловсруулах аргачлал”-ын 4.2.4.2-т заасны дагуу хуулийн төсөлд тусгагдсан “болон” гэснийг хуулийн төслийн зүйл, заалтын агуулгаас хамаарч “эсхүл” гэсэн үгээр сольж өөрчилсөн болно.</p> <p>Мөн хуулийн төслийн зарим эрх зүйн зохицуулалтыг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлсэн.</p> <p>3.Хуулийн төслийн зарим нэр томъёог тайлбарласан зохицуулалтыг ХЗДХЯ болон БХЯ-ны хамтарсан ажлын хэсгээр хэлэлцүүлэн томъёолсон бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.2-т “нэр томъёо нь өргөн утгатай бөгөөд түүнийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай бол” гэж заасны дагуу хуулийн төслийн 3.1.4-т “энхийг дэмжих ажиллагааны сургалт бэлтгэл” гэж тодотгож</p>
---	------	---	--

	<p>4.Төслийн 5.3.6-т “цагийн байдлын өөрчлөлт, үүрэг гүйцэтгэлтийн онцлогт нийцсэн мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн эрхийн хязгаарлалтыг дагаж мөрдөх.” гэж, 6.1.1-т “энхийг дэмжих ажиллагаанд оролцох эрх зүйн үндсийг тогтоох,” гэж заасан нь ойлгомжгүй байх тул дахин найруулах;</p> <p>5.Төслийн 6.1.2-т “Зэвсэгт хүчин, цагдаагийн байгууллагын энхийг дэмжих ажиллагаанд оролцох чадавхыг бүрдүүлэхэд шаардлагатай зардлын төсвийг жил бүр батлах.” гэж заасан нь Улсын төсвийг батлах эрхийг Улсын Их Хуралд олгосон бусад хуулийн зохицуулалттай давхардаж байх тул хасах;</p> <p>6.Төслийн 7.1.3-т “Засгийн газар энхийг дэмжих ажиллагаанд оролцох Зэвсэгт хүчин, цагдаагийн</p>	<p>заасан тул саналыг хүлээн аваагүй болно.</p> <p>4.Хуулийн төслийн 5.3.6 дахь заалтын талаар: Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй цэргийн багийн хариуцлагын бүс дэх цагийн байдал хүндрэх, бие бүрэлдэхүүний амь нас, эрүүл мэндэд аюултай, эрсдэлтэй нөхцөл байдал бий болсон тохиолдолд үүргээ аюулгүй гүйцэтгэх үүднээс хувийн зорилгоор гар утас, зөөврийн болон суурин компьютер хэрэглэх, интернэт сүлжээ ашиглах эрхийг хязгаарлах замаар тэдний сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага үүсдэг болно.</p> <p>Иймд хуулийн төсөлд мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн эрхийн хязгаарлалтыг нарийвчлан тусгах боломжгүй байна.</p> <p>Хуулийн төслийн 6.1-т “Монгол Улсын Их Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:” гэсний 6.1.1-д “энхийг дэмжих ажиллагаанд оролцох эрх зүйн үндсийг тогтоох,” гэсэн нь Монгол Улсын энхийг дэмжих ажиллагаанд оролцох хууль тогтоомжийг Улсын Их Хурлын тогтоолоор батлахтай холбогдох эрх зүйн зохицуулалт бөгөөд “эрх зүйн үндсийг тогтоох” гэсэн хэллэг нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад хууль тогтоомжид байдаг нийтлэг хэллэг тул дахин найруулж өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.</p> <p>5.Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1.7 дахь заалтад нийцүүлэн саналыг хүлээн авч, хуулийн төслийн 6.1.2 дахь заалтыг “энэ хуулийн 7.1.3-т заасан зардлыг жил бүрийн төсөвт тусгах асуудлыг шийдвэрлэх,” гэж өөрчлөн найруулсан болно.</p> <p>6.Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1.8-д “..., харгалзан үзэх нөхцөл байдал, ...” гэж заасантай нийцүүлэн хуулийн</p>
--	--	--

	<p>байгууллагын чадавхыг бүрдүүлэхэд шаардлагатай зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгуулах асуудлыг Улсын Их Хурлаар шийдвэрлүүлэх;" гэсэн нь Улсын төсөв өргөн барих эрхийг Засгийн газарт олгосон бусад хуулийн зохицуулалттай давхардаж байх тул хасах;</p> <p>7.Төсвийн 9.1.4-т “энхийг дэмжих ажиллагаанд оролцох бэлтгэлийг хангах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;”, 10.1.5-д “энхийг дэмжих ажиллагаанд оролцох бэлтгэлийг хангах бодлого боловсруулж хэрэгжүүлэх” гэж тус тус заасан нь төрийн бодлоготой адил утгаар ойлгогдож байх тул “бодлого” гэснийг өөр тохиромжтой үгээр өөрчлөх;</p> <p>8.Төслийн 7.1.7-т Засгийн газар “Нэгдсэн Үндэстний Байгууллагаас олгосон нөхөн төлбөрөөс энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүнд олгох томилолтын зардал болон Зэвсэгт хүчин, Цагдаагийн хөгжлийн санд төвлөрүүлэх хувь хэмжээг тогтоох”-оор тусгасан байна. Өөрөөр хэлбэл, нөхөн төлбөрийг бие бүрэлдэхүүнд олгох томилолтын зардал болон Зэвсэгт хүчин, Цагдаагийн хөгжлийн санд төвлөрүүлэх гэж 2 тусдаа хуваарилахаар заасан байна. Харин төслийн 9.1.6-т Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлан хамгаалахын “энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны нөхөн төлбөрийг Зэвсэгт хүчний тухай хуульд заасны дагуу захиран зарцуулах” гэж заасан нь тус нөхөн төлбөрийг бүхэлд нь зарцуулахаар ойлгогдож байх тул “Засгийн газраас энэхүү хуулийн 7.1.7-т заасны дагуу тогтоосон” гэснийг нэмж тусгах;</p>	<p>төсөлд 7.1.3 дахь заалтыг тусгасан тул саналыг хүлээн аваагүй болно.</p> <p>7.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 11 дэх заалтын 3 дахь дэд заалтад “энхийг дэмжих ажиллагаанд оролцох бэлтгэл хангуулах асуудал” гэсэнтэй нийцүүлэн саналыг хүлээн авч, хуулийн төслийн 9.1.4, 10,1,5 дахь заалтын “... бодлого ...” гэснийг “.. бэлтгэлийг хангуулах асуудлыг” гэж тус тус өөрчлөн найруулсан.</p> <p>8.Саналыг хүлээн авч, хуулийн төслийн 9.1.6 дахь заалтыг “энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны нөхөн төлбөрийг энэ хуулийн 7.1.7-д заасан хувь хэмжээг баримтлан захиран зарцуулах;” гэж өөрчилсөн.</p>
--	--	--

		<p>9.Төслийн 10.1.4-т Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн “энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны нөхөн төлбөрийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу захиран зарцуулах,” гэж заасан нь дээрх 8 дугаар саналд дурдсантай адил утгаар ойлгогдож байх тул тус “Засгийн газрын энэхүү хуулийн 7.1.7-д заасны дагуу тогтоосон” гэснийг нэмж тусгах;</p> <p>10.Төслийн 11.1.5-д “цагийн байдлын өөрчлөлтөөс шалтгаалан” гэснийг ойлгомжтой байдлаар тусгах;</p> <p>11.Төслийн 15.5-д “тухай” гэсний дараа “эсхүл Цагдаагийн албаны тухай” гэж нэмэх.</p>	<p>9.Саналыг хүлээн авч, хуулийн төслийн 10.1.4 дэх заалтыг “энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны нөхөн төлбөрийг энэ хуулийн 7.1.7-д заасан хувь хэмжээг баримтлан захиран зарцуулах,” гэж өөрчилсөн.</p> <p>10.Саналыг хүлээн авч, хуулийн төслийн 11.1.5-д заасан “цагийн байдлын өөрчлөлтөөс шалтгаалан” гэснийг “тухайн газар орны хариуцлагын бүс дэх нөхцөл байдлын өөрчлөлтөөс шалтгаалан” гэж өөрчилсөн.</p> <p>11.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн үйлчлэлд цагдаагийн байгууллагын офицер, ахлагч хамаардаг тул саналыг хүлээн аваагүй болно.</p>
5	БОАЖЯ	<p>2023.10.20-ны өдрийн 01/5582 дугаар албан бичиг: Таны ирүүлсэн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна.</p> <p>Энхийг дэмжих ажиллагаанд оролцогч цэрэг, цагдаагийн алба хаагч үүрэг гүйцэтгэх үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг хуулийн төсөлд тодорхой тусгах боломжийг судлан үзнэ үү.</p>	<p>Хуулийн төслийн 14.4-т “Цэрэг, цагдаагийн алба хаагч энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх үед гэмт хэрэг, зөрчилд холбогдсон тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.” гэж, 16.1-д “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.” гэж тус тус заасан.</p> <p>Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 1.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улсад алба хааж байхдаа гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын цэргийн алба хаагчид энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.” гэж, мөн хуулийн Тусгай ангийн Хорин наймдугаар бүлэгт “Цэргийн албаны эсрэг” 19 төрлийн гэмт хэргийг хуульчилсан.</p> <p>Мөн Цэргийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2 дахь заалтад зааснаар гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон тохиолдолд</p>

			офицер, ахлагчийг нас харгалзахгүйгээр цэргийн жинхэнэ албанаас бэлтгэлээр халах зохицуулалттай байдаг. Цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэх хугацаанд сахилгын зөрчил гаргасан тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 180 дугаар зарлигийн дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Цэргийн сахилгын дүрэм”-д заасны дагуу түүнд сахилгын хариуцлага хүлээлгэнэ.
6	БХБЯ	<p>Таны 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 1а/3720 дугаартай албан бичгээр ирүүлсэн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох материалтай танилцлаа.</p> <p>Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь Зэвсэгт хүчин болон цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүнийг энхийг дэмжих ажиллагаанд оролцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж тусгасан байна.</p> <p>Батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Монгол Улсын төрийн цэргийн байгууллын тогтолцоо нь тайван цагт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг ..., байгууллагаас бүрдэнэ.” гэж заасан байх бөгөөд “Зэвсэгт хүчин” гэх ойлголтод хилийн ба дотоодын цэргийн байгууллага хамаарахгүй байна.</p> <p>Энэ нь зэвсэгт хүчнээс бусад цэргийн алба хаагчийн нийгмийн баталгааг дордуулах, албандаа итгэх итгэл, алба хаах хүсэл зориг, эрмэлзлийг бууруулах, тус байгууллагын албан хаагчдын зэвсэгт хүчин болон цагдаагийн байгууллагад шилжин ажиллах сонирхлыг бий болгох, улмаар хилийн цэрэг болон дотоодын цэргийн байгууллагууд хүний нөөцийн хомсдол үүсэх нөхцөлийг бүрдүүлэхээр байна.</p>	<p>НҮБ-ын Энхийн ажиллагааны газар нь Аюулгүй байдлын институт болон хууль сахиулах газар, Цэргийн харилцааны газар, Бодлого, үнэлгээ, сургалтын газар гэсэн 3 бүрэлдэхүүн хэсэгтэй байдаг. Үүнээс Цэргийн харилцааны газар нь НҮБ-ын энхийн ажиллагаа явагдаж буй улс орнуудад цэргийн баг, бүрэлдэхүүнийг үүрэг гүйцэтгүүлэх асуудлыг, Аюулгүй байдлын институт болон хууль сахиулах газар нь НҮБ-ын энхийн ажиллагаа болон улс төрийн ажиллагаа явагдаж буй улс орны хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах цагдаагийн баг, бүрэлдэхүүнийг үүрэг гүйцэтгүүлэх асуудлыг тус тус хариуцдаг.</p> <p>Өөрөөр хэлбэл, НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаа нь цэргийн эсхүл цагдаагийн баг, бүрэлдэхүүнтэйгээр явагддаг.</p> <p>БНӨСҮ-д явуулж буй НҮБ-ын мандаттай UNMISS энхийг сахиулах ажиллагаанд 1 жилийн хугацаанд үүрэг гүйцэтгэдэг Монгол Улсын Зэвсэгт хүчний 850 хүний бүрэлдэхүүнтэй цэргийн багийн бүрэлдэхүүнд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн дагуу төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдыг тодорхой тооны хязгаартайгаар үүрэг гүйцэтгүүлдэг.</p> <p>Хуулийн төсөл батлагдсанаар хууль сахиулах байгууллагын алба хаагчид цагдаагийн багийн бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэх эрх зүйн орчин бүрдэх ач холбогдолтой юм.</p> <p>Иймд хуулийн төсөлд “Хилийн болон дотоодын цэргийн” гэж</p>

		Иймд хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “болон” гэснийг “, хилийн болон дотоодын цэрэг,” гэж өөрчлөх, мөн хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн, Засгийн газрын тусгайн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “цагдаагийн” гэсний өмнө “Хилийн болон дотоодын цэргийн” гэж тус тус нэмэх саналтай байна.	тусгайлан нэмж тусгах шаардлагагүй бөгөөд цэрэг, цагдаагийн багийн бүрэлдэхүүнд төрийн цэргийн байгууллагаас алба хаагч үүрэг гүйцэтгэх боломж нь нээлттэй байгаа болно.
7	БШУЯ	2023.11.03-ны өдрийн 1а/5240 дүгээр албан бичиг: Таны санал авахаар ирүүлсэн “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай” хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл, танилцуулгатай танилцан тусгайлан өгөх саналгүй байна.	Хуулийн төслийг дэмжсэн.
8	ЗТХЯ	2023.10.24-ний өдрийн 02/5073 дугаар албан бичиг: Таны 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 1а/3720 дугаар албан бичгээр ирүүлсэн “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах саналыг өгч байна. Үүнд: 1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь Зэвсэгт хүчин болон цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүнийг энхийг дэмжих ажиллагаанд оролцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж заасан байгаа нь Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Монгол Улсын төрийн цэргийн байгууллын тогтолцоо нь тайван цагт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ” гэж заасантай нийцэхгүй зөвхөн зэвсэгт хүчин болон	1.НҮБ-ын Энхийн ажиллагааны газар нь Аюулгүй байдлын институт болон хууль сахиулах газар, Цэргийн харилцааны газар, Бодлого, үнэлгээ, сургалтын газар гэсэн 3 бүрэлдэхүүн хэсэгтэй байдаг. Үүнээс Цэргийн харилцааны газар нь НҮБ-ын энхийн ажиллагаа явагдаж буй улс орнуудад цэргийн баг, бүрэлдэхүүнийг үүрэг гүйцэтгүүлэх асуудлыг, Аюулгүй байдлын институт болон хууль сахиулах газар нь НҮБ-ын энхийн ажиллагаа болон улс төрийн ажиллагаа явагдаж буй улс орны хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах цагдаагийн баг, бүрэлдэхүүнийг үүрэг гүйцэтгүүлэх асуудлыг тус тус хариуцдаг.

	<p>цагдаагийн байгууллагын албан хаагчдыг оролцуулахаар заасан байх тул төрийн цэргийн байгууллагын тогтолцоонд хамаарах байгууллагуудыг нэмж тусгах;</p> <p>2.Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д “цэрэг, цагдаагийн баг” гэж НҮБ-аас тогтоосон зохих бүтэц, орон тооны дагуу бие бүрэлдэхүүн болон бүх төрлийн зэвсэглэл, техник тоног төхөөрөмж, эд хэрэгслээр хангагдаж, тавигдсан үүргийг биелүүлэх, чадавх бүхий энхийг дэмжих ажиллагаанд оролцохоор томилогдсон нэгжийг” гэж заасан нь Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Төрийн цэргийн байгууллагууд нь цэргийн эрх зүйн хэм хэмжээ, цэргийн нийтлэг дүрмүүд, цэргийн цол, цэргийн алба хаагчийн бие бялдрын стандарт, энхийг дэмжих ажиллагаанд оролцох байдлаараа нэгдмэл байна” гэж заасантай нийцэхгүй байх тул нэр</p>	<p>Өөрөөр хэлбэл, НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаа нь цэргийн эсхүл цагдаагийн баг, бүрэлдэхүүнтэйгээр явагддаг. БНӨСУ-д явуулж буй НҮБ-ын мандаттай UNMISS энхийг сахиулах ажиллагаанд 1 жилийн хугацаанд үүрэг гүйцэтгэдэг Монгол Улсын Зэвсэгт хүчний 850 хүний бүрлэлдэхүүнтэй цэргийн багийн бүрэлдэхүүнд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн дагуу төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдыг тодорхой тооны хязгаартайгаар үүрэг гүйцэтгүүлдэг.</p> <p>Иймд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод болон НҮБ-ын шаардлагад нийцүүлэн Монгол Улсын Зэвсэгт хүчнээс энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн багийн бүрэлдэхүүнд бусад төрийн цэргийн байгууллагуудын алба хаагчид багтан үүрэг гүйцэтгэх тул цэрэг, цагдаагийн багийн бүрэлдэхүүнд төрийн цэргийн байгууллагаас алба хаагч үүрэг гүйцэтгэх боломж нь нээлттэй байгаа болно.</p> <p>2/3 НҮБ-ын Энхийн ажиллагааны газар нь Аюулгүй байдлын институт болон хууль сахиулах газар, Цэргийн харилцааны газар, Бодлого, үнэлгээ, сургалтын газар гэсэн 3 бүрэлдэхүүн хэсэгтэй байдаг. Үүнээс Цэргийн харилцааны газар нь НҮБ-ын энхийн ажиллагаа явагдаж буй улс орнуудад цэргийн баг, бүрэлдэхүүнийг үүрэг гүйцэтгүүлэх асуудлыг, Аюулгүй байдлын институт болон хууль сахиулах газар нь НҮБ-ын энхийн ажиллагаа болон улс төрийн ажиллагаа явагдаж буй улс орны хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах цагдаагийн баг, бүрэлдэхүүнийг үүрэг гүйцэтгүүлэх асуудлыг тус тус хариуцдаг.</p> <p>Өөрөөр хэлбэл, НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаа нь цэргийн эсхүл Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан “цэрэг, цагдаагийн баг” гэсэн нэр томъёоны тодорхойлолт нь</p>
--	---	---

		<p>томъёоны тодорхойлолтод бусад төрийн цэргийн байгууллагуудыг нэмж тусгах; 3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүн нь цэрэг, цагдаагийн албан хаагч байна” гэж заасан нь төрийн цэргийн байгууллага буюу тагнуул, онцгой байдлын болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бие бүрэлдэхүүнээс энхийг дэмжих ажиллагаанд оролцуулахгүй байхаар тусгасан нь Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Монгол Улсын төрийн цэргийн байгууллын тогтолцоо нь тайван цагт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ” гэж заасантай нийцэхгүй байгаа анхаарах; 4.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.5-д “Цэрэг, цагдаагийн алба хаагч Нэгдсэн Үндэстний Байгууллагаас зарласан энгийн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцэж, үүрэг гүйцэтгэх тохиолдолд албанаас чөлөөлнө” гэж заасан хэдий ч төслийн 15 дугаар зүйлийн 15.3-д “Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хугацаанд цэрэг, цагдаагийн албан хаагчийн албан тушаалыг хэвээр хадгалж, өөрөө зөвшөөрсөн тохиолдолд цалин хөлсийг итгэмжлэгдсэн этгээдэд олгож болно” гэж заасан нь хоорондоо зөрчилдөж байх тул хуульд нийцүүлэх зэрэг болно.</p>	<p>Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон НҮБ-ын шаардлагад нийцэж байгаа тул бусад төрийн цэргийн байгууллагуудын нэмж тусгах шаардлагагүй юм.</p> <p>4.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.5-д заасан эрх зүйн зохицуулалтад цэргийн алба хаагч өөрөө сайн дураар НҮБ-аас зарласан энгийн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцэж үүрэг гүйцэтгэх тохиолдол хамаарах юм. Өөрөөр хэлбэл, тухайн алба хаагчийг захиргааны санаачилгаар томилогдон ажиллах асуудал энд хамаарахгүй тул алба хаасан жилд энгийнээр ажилласан жил тооцогдохгүй гэсэн зохицуулалтын хүрээнд тусгагдсан. Цэргийн алба хаагчийн энгийнээр ажилласан жилийг Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4-д заасан зохицуулалтын хүрээнд шийдвэрлэх боломжтой.</p>
9	СОЁЛЫН ЯАМ	<p>2023.10.20-ны өдрийн 1/2811 дүгээр албан бичиг: Танаас ирүүлсэн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон тус хуулийн төслийг дагалдах хуулийн төслүүдтэй танилцлаа.</p>	Хуулийн төслийг дэмжсэн.

		Хуулийн төслүүдэд тусгайлан өгөх саналгүй байна.	
10	ХХААХҮЯ	2023.10.18-ны өдрийн 01/3604 дүгээр албан бичиг: Танаас 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 1а/3720 тоот албан бичгээр ирүүлсэн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцлаа. Хуулийн төсөлд тусгайлан өгөх саналгүй болно.	Хуулийн төслийг дэмжсэн.
11	УУХҮЯ	2023.10.26-ны өдрийн 03/2560 дугаар албан бичиг: Танаас ирүүлсэн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлалтай танилцаад тусгайлан өгөх саналгүй байна.	Хуулийн төслийг дэмжсэн.
12	ХНХЯ	2023.10.18-ны өдрийн 01/2644 дүгээр албан бичиг: Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлал, танилцуулгатай танилцлаа. Хуулийн төсөлд тусгайлан өгөх саналгүй болно.	Хуулийг төслийг дэмжсэн.
13	ЦХХХЯ	2023.10.31-ний өдрийн 01/2218 дугаар албан бичиг: Танаас ирүүлсэн “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох материалтай танилцлаа. Хуулийн төсөлд тусгайлан өгөх саналгүй болно.	Хуулийн төслийг дэмжсэн.
14	ЭХЯ	2023.10.16-ны өдрийн а/3468 дугаар албан бичиг: Танаас ирүүлсэн “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, холбогдох бусад материалыг хүлээн авч танилцлаа. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зарчмын хувьд дэмжиж байна.	Хуулийн төслийг дэмжсэн.

15	ЭМЯ	<p>2023.11.06-ны өдрийн 1а/4999 дүгээр албан бичиг: Таны ирүүлсэн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, танилцуулга болон холбогдох бусад баримт бичгүүдтэй танилцаж, судалж үзлээ.</p> <p>Зэвсэгт хүчин болон цагдаагийн бие бүрэлдэхүүнд хамаарахгүй эрүүл мэндийн ажилтнууд өөрийн хүсэлтээр энхийг дэмжих ажиллагаанд мэргэжлийнхээ чиглэлээр ажиллах боломж байгаа эсэх, энэ талаарх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах боломжийг анхаарч үзнэ үү.</p>	<p>Өмнө нь энхийг дэмжих ажиллагаанд эмнэлгийн баг үүрэг гүйцэтгэх үед эмнэлгийн энгийн албан хаагчдыг холбогдох сургалтад хамруулсны үндсэн дээр оролцуулж байсан практик байдаг. Харин хуулийн төсөлд Зэвсэгт хүчин болон цагдаагийн бие бүрэлдэхүүнд хамаарахгүй эрүүл мэндийн ажилтнууд өөрийн хүсэлтээр энхийг дэмжих ажиллагаанд мэргэжлийнхээ чиглэлээр ажиллах талаарх эрх зүйн зохицуулалтыг тусгах боломжгүй болно.</p>
----	-----	---	---

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ